

СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
 “ХҮНИЙ НӨӨЦИЙН ХӨГЖИЛ, НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ ХӨТӨЛБӨР”-ИЙГ
 2026 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

2026 оны 03 дугаар сарын 11

Улаанбаатар хот


Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Хүрэх түвшин	Хугацаа	Шаардагдах төсөв	Хариуцах эзэн
1	2	3	4	5	6	7
Зорилт-1 :Төрийн албан хаагчийн цалин хөлс, нөхөх төлбөр, тусламж, шагнал урамшууллыг хууль тогтоомжийн хүрээнд шударга, ил тод, нээлттэй байх зарчмыг баримтлан тогтоож, үр бүтээлтэй, тогтвор суурьшилтай ажиллуулах						
1.	1.1.Албан хаагчдын ажилласан жилийн судалгааг гаргах	Судалгааны тоо	1	I улирал	-	ТЗУХ
	1.2.Дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын тушаалаар албан хаагчдын ээлжийн амралтын хуваарийг батлуулж, хуваарийн дагуу ээлжийн амралтын мэдэгдэх хуудсыг олгох	Батлагдсан хуваарь хэрэгжилт, хувь	Арга хэмжээний хэрэгжилт-100%	I-IV улирал	-	ТЗУХ
	1.3.Төрийн захиргааны албан тушаалтны зэрэг дэв шинээр болон нэмэгдүүлэн авах судалгааг гаргаж Төрийн албаны зөвлөлийн Нийслэл дэх салбар зөвлөлд хүргүүлэх	Саналын тоо хэрэгжилт, хувь	Арга хэмжээний хэрэгжилт-100%	I улирал		ТЗУХ
	1.4.Төрийн захиргааны албан тушаалд анх томилогдон ажиллаж байгаа албан хаагчийг тангараг өргүүлэх саналыг Төрийн албаны зөвлөлийн Нийслэл дэх салбар зөвлөлд хүргүүлэх	Саналын тоо хэрэгжилт, хувь	Арга хэмжээний хэрэгжилт-100%	Жилдээ	-	ТЗУХ
	1.5.Албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний тайлангийн үнэлгээний	Батлагдсан хуваарь,	Арга хэмжээний хэрэгжилт-100%	II, IV улирал	Байгууллагын төсөв	ТЗУХ Үнэлгээний

дүнг үндэслэн урамшуулах болон хариуцлага тооцох арга хэмжээ авах	хэрэгжилт, хувь				баг
1.6.Албан үүргээ үр дүнтэй биелүүлж, өндөр амжилт гаргасан албан хаагчдыг төрийн одон медаль, Засгийн газрын болон Төрийн албаны зөвлөл, нийслэлийн шагналд уламжлах, мөнгөн шагналаар шагнах эд зүйл болон үнэ бүхий зүйл дурсгах	Шагналд уламжлагдсан, шагнагдсан албан хаагчийн тоо	20	I-IV улирал	Байгууллагын төсөв	ТЗУХ
1.7.Ажил үүргийн давхардал, ажлын хэт их ачааллыг оновчтой хуваарилж чиг үүргийн шинжилгээнд үндэслэн бүтцэд өөрчлөлт оруулах	Шийдвэрийн тоо хэрэгжилт, хувь	Арга хэмжээний хэрэгжилт-100%	II улирал	-	ТЗУХ
1.8.Төрийн албан хаагчийг хараат бус, шатлан дэвших зарчмаар албан тушаал дэвшүүлэх	Дэвшүүлэн томилсон албан хаагчдын тоо	3	I-IV улирал	-	ТЗУХ
1.9.Албан хаагчдыг сэлгэн, шилжүүлэн ажиллуулж ажлын байранд хөрвөх чадварыг бий болгох	Ажлын байранд хөрвөх чадвараа нэмсэн албан хаагчдын тоо	3	I-IV улирал	-	ТЗУХ
1.10.Өндөр насны тэтгэвэр тогтоолгож чөлөөлөгдсөн албан хаагчид нэг удаагийн буцалтгүй тусламж олгох	Тусламж олгосон албан хаагчийн тоо	4	I-IV улирал	Байгууллагын төсөв	ТЗУХ
1.11.Ээлжийн амралтаа биеэр эдэлж чадаагүй албан хаагчид 1.5 сарын цалинтай тэнцэх мөнгөн урамшуулал олгох	Албан хаагчийн тоо хэрэгжилт, хувь	Арга хэмжээний хэрэгжилт-100%	I-IV улирал	Байгууллагын төсөв	ТЗУХ
1.12.Төрийн албан хаагчийн өдрийн хоолны зардал болон ажилдаа ирэх, буцахад нийтийн тээврийн хэрэгслээр зорчсон нийтийн тээврийн унааны зардлын хэмжээг үе шаттайгаар нэмэгдүүлэх	Албан хаагчдын ажиллах нөхцөл сайжрах	Арга хэмжээний хэрэгжилт-100%	I-IV улирал	Байгууллагын төсөв	ТЗУХ
Зорилт-2:Албан хаагчдыг орон байраар хангах, амьдрах нөхцөлийг сайжруулах дэмжлэг үзүүлэх					
2.1.Орон байрны нөхцөлөө сайжруулахад мөнгөн тусламж, дэмжлэг үзүүлэх	Дэмжлэг авсан албан хаагчийн тоо	4	I-IV улирал	Байгууллагын төсөв	ТЗУХ, Санхүүгийн тасаг
2.2.Гэр болон галлагаатай байшинд	Дэмжлэг авсан	150	IV улирал	Байгууллагын	ТЗУХ,


	амьдардаг албан хаагчдад түлээ, нүүрсний хөнгөлөлт үзүүлэх	албан хаагчийн тоо			төсөв	Санхүүгийн тасаг
	2.3.Дүүрэгт тогтвор суурьшилтай /3-аас дээш жил/, үр бүтээлтэй ажиллаж буй албан хаагчдын нийгмийн баталгааг хангах зорилгоор Хөдөлмөрийн дотоод журамд нийцүүлэн дэмжлэг үзүүлэх	Нийгмийн асуудлыг шийдвэрлэсэн албан хаагчдын тоо	10	IV улирал	Байгууллагын төсөв	ТЗУХ
	2.4.Шинээр гэр бүл болсон албан хаагч, албан хаагчийн шинэ төрсөн хүүхдэд нэг удаагийн тусламж үзүүлэх	Дэмжлэг авсан албан хаагчийн тоо	10	I-IV улирал	Байгууллагын төсөв	ТЗУХ, Санхүүгийн тасаг
	2.5.Албан хаагчдын ажлын бүтээмж, ачаалал даах болон үүрэг хариуцлага хүлээх, хөрвөх чадварыг нэмэгдүүлэх, цаг үетэйгээ зэрэгцэн өөрийгөө хөгжүүлэх, ажлын чиг үүрэгтэй холбоотой хос мэргэжил эзэмших, мэргэших, магистр, доктор болон бусад төрлөөр суралцахад дэмжлэг үзүүлэх	Дэмжлэг авсан албан хаагчийн тоо	10	I-IV улирал	Байгууллагын төсөв	ТЗУХ, Санхүүгийн тасаг
	2.6.Албан хаагчийн 2 болон түүнээс дээш хүүхэд их дээд сургуульд сурч байгаа тохиолдолд сургалтын төлбөрийн дэмжлэг үзүүлэх	Дэмжлэг авсан албан хаагчийн тоо	2	I-IV улирал	Байгууллагын төсөв	ТЗУХ, Санхүүгийн тасаг
	2.7.Төрийн дээд одон медалиар шагнуулсан албан хаагчдад мөнгөн урамшуулал олгох	Дэмжлэг авсан албан хаагчийн тоо	5	I-IV улирал	Байгууллагын төсөв	ТЗУХ, Санхүүгийн тасаг
	2.8.Албан хаагчийн эхнэр/нөхөр, төрсөн эцэг эх, хадам эцэг эх, үр хүүхэд, төрсөн ах, эгч нас барсан тохиолдолд буцалтгүй тусламж олгох	Албан хаагчийн тоо хэрэгжилт, хувь	Арга хэмжээний хэрэгжилт-100%	I-IV улирал	Байгууллагын төсөв	ТЗУХ, Санхүүгийн тасаг
Зорилт-3:Албан хаагчдын ажлын байрны орчин нөхцөл, хангамжийг сайжруулах						
3.	3.1.Албан хаагчдыг сүүлийн үеийн технологийн шаардлага хангахуйц компьютер, техник хэрэгсэл, бичиг хэргийн хэрэгслээр хангах	Албан хаагчдын ажиллах нөхцөл сайжрах	Арга хэмжээний хэрэгжилт, хувь	I-IV улирал	Байгууллагын төсөв	ААТасаг, СТасаг
	3.2.Албан хаагчдын ажлын байрыг	Албан хаагчдын	Арга хэмжээний	I-IV	Байгууллагын	ААТасаг,

	стандартад нийцүүлж, засвар үйлчилгээ хийх	ажиллах нөхцөл сайжрах	хэрэгжилт, хувь	улирал	төсөв	СТасаг
	3.3.Албан хаагчдын ерөө тасалгааны хүрээлцээтэй байдлыг нэмэгдүүлж, ажлын орчныг сайжруулах	Албан хаагчдын ажиллах нөхцөл сайжрах	Арга хэмжээний хэрэгжилт, хувь	I-IV улирал	Байгууллагын төсөв	ААТасаг, СТасаг
Зорилт-4:Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, бие бялдрыг хөгжүүлэх						
4.	4.1.Албан хаагчдыг жилд 1 удаа нарийн мэргэжлийн үзлэг, оношилгоонд хамруулах	Үзлэгт хамрагдсан албан хаагчдын тоо	190	I-II улирал	Байгууллагын төсөв	ТЗУХ, НХХ
	4.2.Албан хаагчдын хамт олонч уур амьсгалыг бүрдүүлэх, амралт чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх зорилгоор албан хаагчдын дунд нийтийг хамарсан тэмцээн, уралдаан, идэвхтэй амралт, явган аялал зохион байгуулах	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	1	III улирал	Байгууллагын төсөв	ТЗУХ
	4.3.Биеийг чийрэгжүүлэх, бялдаржуулах, спортоор хичээллэхэд дэмжлэг үзүүлэх	Дэмжлэг авсан албан хаагчдын тоо	20	I-IV улирал	Байгууллагын төсөв	ТЗУХ, НХХ
	4.4.Гадаад улс оронд онош тодруулах, эмчлүүлсэн албан хаагчийн эмчилгээний зардлын тодорхой хувьд дэмжлэг үзүүлэх	Дэмжлэг авсан албан хаагчдын тоо	2	I-IV улирал	Байгууллагын төсөв	ТЗУХ

ХЯНАСАН:

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
ДАРГА  А.БЯМБА

БОЛОВСРУУЛСАН:

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
МЭРГЭЖИЛТЭН  Ц.МӨНХЦЭЦЭГ